

**НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН “САХИЛГА ХАРИУЦЛАГА, ДЭГ ЖУРМЫГ САЙЖРУУЛАХ ТУХАЙ”
2017 ОНЫ 02 ДУГААР АЛБАН ДААЛГАВРЫГ ХЭРЭГЖҮҮЛЭХ АЖЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ**

2017 оны 09 дүгээр сарын 05

Д/д	Заалтын дугаар	Албан даалгаврын заалт	Хэрэгжүүлэх үйл ажиллагаа	Хугацаа	Биелэлт
1	2	3	4	5	6
1.	Хоёр.	Төрийн байгууллага, албан тушаалтны сахилга хариуцлагыг өндөржүүлж, гал ус, газар хөдлөлт зэрэг болзошгүй аюулаас урьдчилан сэргийлэх, Төрийн албаны тухай хууль, холбогдох дүрэм журам, заавар, зөвлөмжийн дагуу байгууллагын үйл ажиллагааны төлөвлөлт, гүйцэтгэл, үр дүнг сайжруулах, төрийн албаны стандартыг мөрдөж ажиллах.	<p>1.Албаны хэлтэс, харьяа газруудын захиргааны чиглэлийн дотоод үйл ажиллагаанд батлагдсан төлөвлөгөө, удирдамжийн дагуу дараах чиглэлүүдээр дотоод хяналт, шинжилгээ үнэлгээний ажлуудыг явуулж, хэрэгжилт үр дүнг тооцож тайлагнаж ажиллах.</p> <ul style="list-style-type: none"> • Нийслэлийн эдийн засаг нийгмийг 2017 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн хэрэгжилт, • Албанд хамаарах дээд газрын тогтоол шийдвэр болон бодлогын зорилтын хэрэгжилт, • Албаны жилийн үйл ажиллагааны төлөвлөгөө, хэрэгжилт, үр дүн. • ХЕМ-ийн тушаал, албан даалгаврын хэрэгжилт, • Хотын ерөнхий менежерийн зөвлөлийн хурлын шийдвэрийн хэрэгжилт, 	Жилдээ	<p>Аудит, дотоод хяналтын хэлтсээс УБЗАА-наас 2017 онд хэрэгжүүлэх “Дотоод хяналт шалгалтын ажлын төлөвлөгөө”-г хот нийтийн аж ахуйн 4 төрлөөр 50 ажил үйлчилгээнд ХШҮ хийхээр боловсруулж, ХЕМ-ээр батлуулан, хэрэгжилтийг ханган ажиллаж байна. 2017 оны 09 дүгээр сарын байдлаар дараахи ажлуудыг хийж гүйцэтгэсэн байна. Үүнд:</p> <ol style="list-style-type: none"> 1.НЭЗН-ийг 2017 онд хөгжүүлэх үндсэн чиглэлд тусгагдсан шинээр баталж мөрдүүлэх 19 эрх зүйн баримт бичгийн ажлын явцад 3 удаа, бусад төлөвлөгдсөн ажлуудын хэрэгжилтэд 3 удаа ХШҮ хийж, ХЕМ-ийн зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж, удаашралтай хэрэгжиж байгаа 19 ажилд “Мэдэгдэх хуудас” үйлдэж, хэлтсүүдийг үүрэгжүүлж, хяналт тавьж ажилласан. 2.Дээд газрын тогтоол шийдвэрийн хэрэгжилтэд улирал тутам, НЗД-ын зөвлөлийн хурлын тэмдэглэл, НЗД-аас өгсөн үүргийн хэрэгжилтэд улирал, сар тутам хяналт тавьж, удаашралтай хэрэгжиж байгаа ажлуудыг ХЕМ болон хэлтсийн дарга нарт мэдээлж, ажлыг эрчимжүүлж байна. 3.Албаны үйл ажиллагааны төлөвлөгөөний эхний хагас жилийн төлөвлөгөө 86,1 хувьтай хэрэгжсэнийг НЗДТГ-т хүргүүлсэн ба төлөвлөсөн ажлын хэрэгжилтэд Аудит, дотоод хяналтын хэлтэс ХШҮ хийж, ХЕМ-ийн зөвлөлийн хуралд танилцуулан огт хэрэгжээгүй, удаашралтай 3 ажилд “Мэдэгдэх хуудас” үйлдэж, хэлтсүүдэд хүргүүлж, хэрэгжилтийг хангуулсан. Мөн тус алба 14 хоног тутам ажлын төлөвлөгөө гаргаж, мэдээ тайланг НЗДТГ-т хүргүүлж хэвшсэн байна. 4. ХЕМ иргэн, ААНБ-уудаас ирүүлсэн албан бичиг, өргөдөл, гомдолтой танилцан, эргэн танилцуулах, хэрхэн шийдвэрлэх талаар заавар зөвлөмж өгсөн бичгүүдэд өдөр

			<ul style="list-style-type: none"> Архив, албан хэрэг хөтлөлт, баримт бичгийн стандартын хэрэгжилт. 		<p>тутмын хяналт тавьж ажиллаж байна. Мөн ХЕМ-ийн өгсөн үүргийн дагуу шуурхай ажил хариуцсан ахлах мэргэжилтэн Б.Мөнхбаяраар ахлуулан 8 хүний бүрэлдэхүүнтэй баг ногоон байгууламжийн арчилгаа, тордолгооны 54 ААНБ-уудаар явж үзлэг, шалгалт хийж дүнг ХЕМ-т танилцуулав. Дүнгээр 11 байгууллага гэрээний үүргээ хангалтгүй биелүүлж байгаа дүн гарлаа.</p> <p>Эдгээр ногоон байгууламжийн арчлалт, хамгаалалтын ажлыг хийж, гүйцэтгэж буй ААНБ-уудад сар бүр хяналт тавьж байна.</p> <p>Сөүлийн гудамжийг “Шөнийн гэрэлт гудамж” болгон тохижуулах ажлын хүрээнд тус албанаас 2017 оны 4-6 тогтмол хяналт тавин, амралтын өдрүүдэд нийт албаны ажилтнуудыг хамруулсан хуваарь гарган хяналт тавьж ажиллав.</p> <p>5. ХЕМ-ийн зөвлөлийн хурлаар хэлэлцүүлсэн “Согтууруулах ундаагаар худалдаа үйлчилгээ эрхлэх, зөвшөөрөл олгох” асуудлын мөрөөр хурлын шийдвэр болон тушаалын хэрэгжилтэд ХШҮ хийж, дүгнэлт гаргасан ба санал зөвлөмжийг албажуулж, Хүнс, худалдаа үйлчилгээний хэлтсийн даргад танилцуулж өгсөн.</p> <p>6. Архив, албан хэрэг хөтлөлт, баримт бичгийн стандартын талаарх мэдээ, мэдээллийг албаны дотоод сүлжээ, фэйсбүүк, мэдээллийн самбараар дамжуулан хүргэж байна. Мөн нийт ажилтнуудад тогтмол заавар, зөвлөгөө өгч, хяналт тавин ажиллаж байна.</p> <p>Хэрэгжих шатандаа 90%</p>
2.	Гурав.	Төрийн албан хаагчдын хууль тогтоомж, дүрэм журмын хэрэгжилтийг хангуулах, иргэдэд хүнд суртал, чирэгдэл, ёс зүйн доголдол гаргахгүй үйлчлэх, зөрчил гаргасан албан хаагчдад захиргааны хариуцлага хүлээлгэж холбогдох байгууллага, иргэд,	1.Албанд ирсэн өргөдөл гомдлын шийдвэрлэлтэд хяналт шинжилгээ үнэлгээ хийж, үр дүнг Хотын Ерөнхий менежерийн зөвлөлийн хуралд танилцуулж, илтгэх хуудсаар НЗДТГ-т тайлагнаж ажиллах.	2, 4 дүгээр улиралд	<p>1.Өргөдөл гомдлын шийдвэрлэлт, хариутай бичгийн шийдвэрлэлтэд 1 удаа ХШҮ хийж, танилцуулга мэдээллийг Захиргаа санхүүгийн хэлтст өгсөн ба нэгтгэж, ХЕМ-ийн зөвлөлийн хуралд танилцуулсан.</p> <p>2. Албаны хэлтсүүдийн дотоод ажилд ХШҮ хийх удирдамж гарган, ХЕМ-ээр 2017.07.31-ний өдөр батлуулсан ба захиргаа, хүний нөөц, дотоод ажил, тушаал, хурлын шийдвэрийн хэрэгжилт, ААХХ-ийн үйл ажиллагаа, санхүү нягтлан бодох бүртгэл, шилэн дансны хуулийн хэрэгжилтэд ХШҮ явуулж байна. Уг ажлыг 8-10 дугаар сард хэрэгжүүлэхээр төлөвлөсөн.</p>

		ажилтнууддаа мэдээлдэг байх.			3.Захирагчийн харьяа 11 байгууллагад 2017 оны 04 дүгээр сард ХЕМ-ийн баталсан удирдамжийн хүрээнд “Хянан зааварлах, зөвлөн туслах ажил”-ыг явуулж, ажлын байран дээр заавар зөвлөмж өгч ажилласан. Хяналтын чиглэлд дүрмээр хүлээсэн үүргийн хэрэгжилт, захиргааны удирдлага зохион байгуулалт, хүний нөөц, дотоод ажил, ААХХ-ийн үйл ажиллагаа, дээд газрын тогтоол шийдвэр, жил, улирлын төлөвлөгөө тайлан, ил тод байдал, санхүү, шилэн дансны хуулийн хэрэгжилт зэрэг асуудлуудыг хамруулсан ба бусад мэргэжлийн хэлтсүүдээс хариуцсан мэргэжилтнүүдийг ажлын хэсгийн бүрэлдэхүүнд хамруулсан. Биелсэн 100%
3.	Тав.	Нийслэлээс зарласан хурал, удирдах ажилтнуудын шуурхай зөвлөгөөн, олон нийтийн арга хэмжээнүүдэд өөрийн биеэр ирж ажил хэрэгч оролцох, хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр хоцорч, таслахгүй байх, нийтээр тэмдэглэх баяр ёслол болон амралтын өдрүүд, ажлын бус цагаар гар утсаа нээлттэй байлгаж, онцгой тохиолдолд ажиллахад бэлэн байх, нийслэлийн удирдлагуудаас цаг үеийн үүссэн нөхцөл байдалтай уялдуулан өгсөн үүрэг даалгаврыг удирдлага, ажилтан нэг бүр шуурхай зохион байгуулж, ажлын явц үр дүнг тогтоосон хугацаанд танилцуулж байх.	1.Нийслэлээс удирдах ажилтны шуурхай зөвлөгөөнөөс өгсөн үүргийн хэрэгжилтэд хяналт тавьж, гүйцэтгэл үр дүнг тооцож, тайлагнаж ажиллах.	Жилдээ	Нийслэлийн удирдах ажилтны шуурхай зөвлөгөөнөөс өгсөн үүргийг хэрэгжүүлэн ажиллаж, хэрэгжилтийг тухай бүр заасан хугацаанд хуваарийн дагуу гаргаж Аудит, дотоод хяналт хэлтсээр хянуулан, НЗДТГ-г хүргүүлж байна. Мөн НЗД-ын шуурхай зөвлөгөөнд УБЗАА-наас танилцуулагдах мэдээлэл тухайлбал, өвөлжилтийн бэлтгэл хэрхэн хангагдаж байгаа зэргээр мэдээлэл, /PPT/ танилцуулгуудыг бэлтгэн хянаж, санал тусгаж ажилласан. Биелсэн 100%
			2.Удирдлагаас өгсөн чиглэл, байгууллагын дотоод журам болон төрийн албан хаагчийн ёс зүйн дүрэм журмыг мөрдлөг болгож ажиллах, дотоод журмын хэрэгжилтэд хяналт шинжилгээ үнэлгээ хийж ажиллах.	Жилдээ	2017 онд байгууллагын дотоод журам, ёс зүйн дүрмийг шинэчлэн батлуулсан, мөн ёс зүйн хороог шинээр байгуулж, ёс зүйн хорооны ажиллах журмыг батлан мөрдүүлж ажиллаж байна. Журмын дагуу ёс зүйн хороогоор 2 ажилтны асуудлыг хэлэлцэж, сахилгын шийтгэл ногдуулах арга хэмжээ, иргэдээс 4 албан хаагчтай холбоотой гомдол ирснийг хэлэлцэж сануулах арга хэмжээ авлаа. Мөн дотоод журамд заасны дагуу ажилтнуудын ажлын цаг ашиглалтад сар бүр хяналт тавьж, эхний хагас жилийн ажил дүгнэх үзүүлэлтэд тусгасан, жилийн эцсийн үр дүнгийн гэрээ дүгнэхэд мөн харгалзан ажиллах юм. Албаны хэлтсүүдийн дотоод ажилд ХШҮ хийх удирдамжид гарган, ХЕМ-ээр 2017.07.31-ний өдөр батлуулсан ба дотоод журмын хэрэгжилтийн зарим заалт болон цаг ашиглалтын байдалд ХШҮ хийж байна. /Үргэлжилж байна/ Хэрэгжих шатандаа 70%

4.	6.1.	<p>Хүнсний аюулгүй байдлыг хангах, спирт, согтууруулах ундаа, түргэн муудах, хүнсний бүтээгдэхүүн үйлдвэрлэгч, худалдан борлуулагч, түүгээр үйлчилгээ үзүүлэгч аж ахуйн нэгжийн үйл ажиллагаанд холбогдох хууль тогтоомж, стандартын дагуу тавих байнгын хяналтыг эрс сайжруулж тогтоосон стандарт, байршил, цагийн хуваарийг мөрдлөг болгон сахиулах, илэрсэн зөрчлийг таслан зогсоох, арилгах арга хэмжээг түргэн шуурхай авч ажиллах.</p>	<p>1.Хүнсний биш бараа, жижиглэн худалдааны цэгүүдийн үйл ажиллагаанд холбогдох хууль тогтоомж, шийдвэрийн хэрэгжилтийг хангуулах чиглэлээр мэргэжлийн байгууллагуудтай хамтран хяналт тавьж ажиллах.</p>	1-12 сар	<ul style="list-style-type: none"> • Сар шинийн баярыг угтан нийслэлийн хэмжээнд нийт 17 байршилд өргөтгөсөн худалдаа зохион байгуулж, хүнсний бүтээгдэхүүний чанар, аюулгүй байдалд дүүргийн ЗДТГ-ын ХХҮХ, МХХ-тэй хамтран хяналт тавьж ажилласан. • Нийслэлийн Засаг даргын 2017.01.24-ний өдрийн “Хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах талаар авах зарим арга хэмжээний тухай” А/31 дүгээр захирамжийг дүүргүүдийн Засаг дарга нарт хүргүүлж хяналт тавьж ажилласан. Ил задгай худалдаа, мал амьтны гаралтай түүхий эдийн худалдааг зогсоох, зах, худалдааны төвүүдийн гадна талбай дахь зөвшөөрөлгүй ил задгай худалдааг цэгцлэх, ил задгай худалдааг тодорхой цэгт төвлөрүүлэн байршуулах талаар дүүргүүд тодорхой арга хэмжээ аваагүй байна. Чингэлтэй дүүрэгт “Зөрчил”, “Хяналт” нэгдсэн арга хэмжээний хүрээнд зөвшөөрөлгүй ил задгай худалдаанд хяналт шалгалт хийж, удаа дараа зөрчил гаргасан 8 иргэнийг шүүхэд шилжүүлсэн байна. • Нийтийн эзэмшлийн гудамж, зам талбай дахь зөвшөөрөлгүй ил задгай худалдааг цэгцлэх, хүнсний аюулгүй байдал, иргэдийн эрүүл ахуй, аюулгүй орчинд амьдрах нөхцлийг хангуулах зорилгоор Улаанбаатар хотын Ерөнхий менежерийн 2017 оны 08 дугаар сарын 25-ны өдрийн А/134 тоот “Ажлын хэсэг байгуулж, хяналт шалгалт хийх тухай” тушаалаар баталсан удирдамжийн дагуу дүүргийн Засаг даргын Тамгын газар, Мэргэжлийн хяналтын хэлтэс, Цагдаагийн хэлтэстэй хамтран шалгалт хийсэн. Шалгалтаар төвийн 6 дүүргийн 22 байршил дахь ил задгай худалдаа эрхлэгч 311 иргэнийг хамруулан, 12 байршилд нийтийн эзэмшлийн зам талбайг бүрэн чөлөөлүүлж, холбогдох арга хэмжээ авсан. <p>Хэрэгжих шатандаа 90%</p>
			<p>2.Нийслэлийн төвийн 6 дүүргийн нутаг дэвсгэрт үйл</p>	1-2 сар	<p>Нийслэлийн Засаг даргын Зөвлөлийн хурлаас өгсөн үүргийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд Хотын Ерөнхий менежерийн</p>

			ажиллагаа явуулж буй согтууруулах ундаагаар үйлчлэх тусгай зөвшөөрөлтэй газруудад шалгалт хийх.		2017 оны А/01 дүгээр тушаалаар батлагдсан удирдамжийн дагуу Нийслэлийн төвийн 6 дүүргийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй согтууруулах ундаагаар үйлчлэх тусгай зөвшөөрөлтэй газруудад шалгалт хийх удирдамж"-ийн дагуу хийсэн шалгалтын дүнг нэгтгэж байна. Шалгалтаар ажлын хэсгүүд хамрагдвал зохих 1435 аж ахуйн нэгжээс 1318 буюу 91,8 хувийг хамруулсан, 117 аж ахуйн нэгжийн үйл ажиллагааны чиглэл өөрчлөгдсөн болон үйл ажиллагаа явуулаагүй байна. Холбогдох хууль тогтоомжийг зөрчсөн 184 аж ахуйн нэгжид 43,310,000 төгрөгийн торгуулийн арга хэмжээ авч, илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулахаар 49 аж ахуйн нэгжид 310 заалт бүхий улсын байцаагчийн хугацаатай албан шаардлага хүргүүлж ажилласан. Шалгалтаар стандартын хэрэгжилт дунджаар 75%-тай дүгнэгдсэн. Шалгалтын дүнг үндэслэн санал, дүгнэлт боловсруулж Нийслэлийн Засаг даргын Зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэхэд бэлэн болгосон. Хэрэгжих шатандаа 90%
			3.Согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрлийн хүсэлт ирүүлсэн газруудад анхан шатны хяналт хийж, саналыг Ерөнхий менежерийн Зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж, шийдвэр гаргуулах.	1-12 сар	Нийслэлийн үйлчилгээний нэгдсэн програмд бүртгэгдсэн 740 БААН-ийн хүсэлтийг хүлээн авч, анхан шатны хяналтаар 79 аж ахуйн нэгжийн материалын бүрдэл дутуу, холбогдох стандартын шаардлага хангахгүйгээс буцааж, 661 аж ахуйн нэгжийн материалыг Ерөнхий менежерийн 10 удаагийн зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж шийдвэр гаргуулсан. Хурлаас гарсан шийдвэрийн дагуу Хотын Ерөнхий менежерийн тушаалаар 253 ААН-д тусгай зөвшөөрөл шинээр олгож, 169 ААН-ийн тусгай зөвшөөрлийг сунгаж, 36 ААН-ийн нэр шилжүүлж, 10 ААН-ийн эрхийг сэргээж, 62 ААН-ийн тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлж, 232 ААН-ийн тусгай зөвшөөрлийг хүчингүй болгон, www.ubservice.mn сайтад байршуулж, нийтэд мэдээлсэн. Хэрэгжих шатандаа 90%
			4.Согтууруулах ундаа худалдах түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрөлтэй газруудыг аттестатчилах.	5-7 сар	Согтууруулах ундаа худалдах түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрөлтэй газруудад холбогдох хууль тогтоомж, журам, стандартын хэрэгжилтийг хангуулах зорилгоор аттестатчиллын шалгалтыг Хотын Ерөнхий менежерийн баталсан удирдамжийн дагуу 2017 оны 05 дугаар сарын 25-ны өдрөөс 06 дугаар сарын 25-ны хооронд зохион байгуулж,

				<p>нийслэлийн 9 дүүргийн баар кафе, рестораны чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг 1109, худалдааны чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг 2196, нийт 3305 ААН-ийг хамруулсан. Аттестатчиллын явцад 1362 ААН-ид хугацаатай үүрэг даалгавар өгч, хоол үйлдвэрлэл үйлчилгээний 519, худалдааны 1224 ААН-ийн тусгай зөвшөөрлийн хугацааг сунган, 197 ААН-ийн тусгай зөвшөөрлийг хүчингүй болгож, 3 ААН-ийн тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлэн холбогдох хууль тогтоомж, журмын хэрэгжилт, стандартын шаардлагыг хангуулах арга хэмжээ авсан.</p> <p>Хэрэгжих шатандаа 90 %</p>
		<p>5.Түргэн үйлчилгээний цэгийн худалдаа үйлчилгээ эрхлэгчдийн үйл ажиллагаанд жилд 1-ээс доошгүй удаа хяналт шалгалт явуулж, журмын хэрэгжилтэд хяналт тавьж, гүйцэтгэл үр дүнг тайлагнаж ажиллах.</p>	<p>Жилдээ /1-ээс доошгүй удаа/</p>	<p>1.НИТХ-ын 2014 оны 56 дугаар тогтоолоор батлагдсан “Нийслэлийн нутаг дэвсгэрт түргэн үйлчилгээний цэг ажиллуулах журам”-ыг шинэчилж, НИТХ-аар хэлэлцүүлж дэмжигдсэн ба Хууль зүйн яаманд бүртгэгдээгүй, албан ёсоор баталгаажиж ирээгүй байна. Шинэчлэгдсэн журмын хэрэгжилтэд хяналт шалгалт явуулахаар төлөвлөсөн ба хүлээгдэж байна.</p> <p>2.Иргэдээс ирүүлсэн гомдол мэдээллийн мөрөөр 2 удаа ТҮЦ-ийн үйл ажиллагаанд шалгалт явуулж, хуулиар хориглосон бараа бүтээгдэхүүн худалдан борлуулж байсан зөрчлийн мөрөөр үйл ажиллагааг түр хаалгасан болно.</p> <p>Хэрэгжих шатандаа 70%</p>
		<p>6.Согтууруулах ундаа, түүгээр үйлчилгээ үзүүлж буй байгууллагуудад буюу тусгай зөвшөөрөл олгох үйл ажиллагаа, холбогдох журмын хэрэгжилтэд тодорхой арга аргачлалаар хяналт тавьж, гүйцэтгэл үр дүнг тооцож, тайлагнаж ажиллах.</p>	<p>Жилдээ /2-оос доошгүй удаа/</p>	<p>ХЕМ-ээр батлуулсан удирдамжийн хүрээнд ХЕМ-ийн зөвлөлийн хурлаар зөвшөөрөл олгосон согтууруулах ундаагаар худалдаа үйлчилгээ эрхэлж буй ААНБ-д /50/ түүвэрчилсэн хэлбэрээр Хяналт шалгалт явуулж, илэрсэн алдаа дутагдлын хүрээнд баримт бичгийн бүрдлийг хангуулж, орчны тохижилтыг сайжруулах, журмын холбогдох заалтуудыг хэрэгжүүлэх хүрээнд хугацаатай үүрэг чиглэл өгч хэрэгжилтийг хангуулж байна. /Үргэлжилж байна/</p> <p>Хэрэгжих шатандаа 70%</p>
		<p>7.Согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрөлтэй</p>	<p>Жилдээ</p>	<ul style="list-style-type: none"> НИТХТ-ийн 2017 оны “Хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах талаар авах зарим арга хэмжээний тухай” 19 дүгээр тогтоолын хэрэгжилтэнд Улаанбаатар хотын

			газруудад мэргэжлийн байгууллагуудтай хамтран хяналт тавьж ажиллах.		<p>Цагдаагийн газар, НМХГ, дүүргүүдийн ЗДТГ-тай хамтран хяналт тавьж, шалгалтын явцад илэрсэн зөрчлийн дагуу Улаанбаатар хотын Цагдаагийн газар, НМХГ-аас ирүүлсэн саналыг үндэслэн Хотын Ерөнхий менежерийн 2017.02.08-ны өдрийн А/22 тоот тушаалаар 1 ААН-ийн тусгай зөвшөөрлийг хүчингүй болгож, 17 ААН-ийн тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлж, Улаанбаатар хотын Цагдаагийн газар, Нийслэлийн Мэргэжлийн хяналтын газарт албан бичгээр хүргүүлж, ubservice.mn сайтад байршуулж нийтэд мэдээлсэн.</p> <ul style="list-style-type: none"> Иргэдээс ирүүлсэн гомдлын дагуу согтууруулах ундаагаар үйлчлэх тусгай зөвшөөрөлтэй 3, худалдах тусгай зөвшөөрөлтэй 1 ААН-ийн үйл ажиллагаанд шалгалт хийж, зөрчлийг арилгуулж, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгсөн. НМХГ-аас ирүүлсэн албан бичгийн дагуу Баянгол дүүргийн 2-р хороонд байрлах Сэлэнгэ хийморь ХХК-ийн хүнсний дэлгүүрт шалгалт хийж, тусгай зөвшөөрлийг цуцлах саналыг Хотын Ерөнхий менежерийн Зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж шийдвэрлүүлсэн. <p>Хэрэгжих шатандаа 90%</p>
5	Гурав.	Төрийн албан хаагчдын хууль тогтоомж, дүрэм журмын хэрэгжилтийг хангуулах, иргэдэд хүнд суртал, чирэгдэл, ёс зүйн доголдол гаргахгүй үйлчлэх, зөрчил гаргасан албан хаагчдад захиргааны хариуцлага хүлээлгэж холбогдох байгууллага, иргэд, ажилтнууддаа мэдээлдэг байх.	1.Албан хаагчдын ажлын байрны тодорхойлолтод сахилга хариуцлагыг тодорхой болгож, шинэчлэн боловсруулж батлуулах	1 дүгээр улиралд	<p>Албан хаагчдын ажлын байрны тодорхойлолтыг албаны дүрэмд тусгагдсан үндсэн чиг үүргийн хүрээнд шинэчлэн боловсруулсан, мөн ажлын байрны тодорхойлолтод сахилга хариуцлагыг тодорхой болгож батлууллаа.</p> <p>Биелсэн 100%</p>
			2.Албаны дотоод журмыг шинэчлэн боловсруулж, батлуулах	1 дүгээр улиралд	<p>Албаны дотоод журмын төслийг боловсруулж, хэлтсүүдээс санал авч нэгтгэн Ерөнхий менежерийн зөвлөлийн хурлаар оруулж, хэлэлцүүлэн ХЕМ-ийн 2017 оны Б/48 дугаар тушаалаар батлууллаа.</p> <p>Биелсэн 100%</p>

			3.Төрийн албан хаагчдын ёс зүйн дүрмийг шинэчлэн батлуулах	1 дүгээр улиралд	Албаны ёс зүйн дүрмийн төслийг шинэчлэн боловсруулж, хэлтсүүдээс санал авч нэгтгэн Ерөнхий менежерийн зөвлөлийн хурлаар оруулж, хэлэлцүүлэн ХЕМ-ийн Б/48 дугаар тушаалаар батлуулав. Мөн албан хаагчдын саналд тулгуурлан ёс зүйн хороог шинэчлэн ХЕМ-ийн 2017 оны Б/54 дугаар тушаалаар, ёс зүйн хорооны ажиллах журмыг ХЕМ-ийн Б/52 дугаар тушаалаар батлуулав. Биелсэн 100%
6	9.1	Инженерийн шугам сүлжээний хэвийн, найдвартай ажиллагааг хангаж, байгууллага, иргэдийг ус, дулаан, цахилгаан хангамжаар тасалдуулахгүй, гэнэтийн гэмтэл, саатал, аливаа эрсдэлээс урьдчилан сэргийлэх, шуурхай ажиллагааны бүлэг, жижүүрийн хуваарь гаргуулах, техник хэрэгслийн бэлэн байдлыг хангуулах үйл ажиллагааг удирдан зохион байгуулах	1.Инженерийн шугам сүлжээний хэвийн, найдвартай ажиллагааг хангах чиглэлээр шуурхай ажиллагааны бүлэг, жижүүрийн хуваарь гаргуулах, техник хэрэгслийн бэлэн байдлыг хангуулах үйл ажиллагааг удирдан зохион байгуулах	Жилдээ	<ul style="list-style-type: none"> Цагаан сар, наадмын өдрүүдэд нийслэлийн төр захиргааны байгууллагын удирдах ажилтнуудыг Улаанбаатар хотын шуурхай удирдлага зохицуулалтын төв дээр ажиллуулах хуваарийг Хотын Ерөнхий менежерээр батлуулан ажилласан. Улаанбаатар хотын Ерөнхий менежерийн 2017 оны 03 дугаар сарын 17-ны өдрийн А/46 дугаар тушаалаар Шугам сүлжээний үзлэг, тооллого явуулах тухай ажлын хэсэг байгуулагдан шугам сүлжээний ашиглалтын байгууллагуудын хөрөнгөд байгаа шугам сүлжээний мэдээлэл, зураглал бэлтгэн Улаанбаатар хотын Ерөнхий менежерт дүнг нэгтгэн танилцуулсан. Мөн Улаанбаатар хотын Ерөнхий менежерийн 2017 оны 02 дугаар сарын 20-ны өдрийн А/35 дугаар тушаалаар Улаанбаатар хотын хэмжээний “Барилга байгууламжийн лифт өргөх байгууламжид хяналт шалгалт хийж үнэлэлт дүгнэлт өгөх, цаашид хэрэгжүүлэх ажлын санал боловсруулах ажлын хэсэг” байгуулагдан 2017 оны 05 дугаар сарын 15-ны өдөр хүртэл үзлэг, хяналт шалгалтын ажлыг явуулсан. Уг ажлын хэсэг Нийслэлийн Мэргэжлийн хяналтын газарт бүртгэлтэй орон сууц болон олон нийтийн барилгын 4688 лифтэнд хяналт шалгалт хийхээс 1518 лифтэнд хяналт шалгалт хийсэн ба А/35 дугаар тушаалын ажлын хэсгийг үргэлжлүүлэхээр болж 2017 оны 08 дугаар сарын 15-ны өдрийн А/131 дүгээр тушаалаар барилга байгууламжийн лифт, өргөх байгууламжид хяналт, шалгалт хийж, дүгнэлт гаргах ажлын хэсгийг Нийслэлийн Цагдаагийн газраас төлөөлөл оруулан тушаалыг шинэчлэн гарган 2017 оны 09 дүгээр сарын 04-ний өдрөөс хяналт,

				<p>шалгалт үргэлжлэн явагдаж байна. Нийслэлийн Мэргэжлийн хяналтын газрын дүгнэлт гарсан солих шаардлагатай 184 лифт байдаг ба 2017 оны төсвийн тодотголд тусгуулахаар 40 лифтний 3,4 тэрбум төгрөгийг шийдвэрлүүлэхээр тус албаны 2017.03.06-ны өдрийн 01/280 дугаар албан бичгээр НЗДТГ-ын Бодлого, төлөвлөлтийн хэлтэст хүргүүлсэн боловч батлагдаагүй тул 2018 оны улсын төсвийн саналд нэн даруй солих шаардлагатай 80 лифтний 6,8 тэрбум төгрөгийг шийдвэрлүүлэхээр санал хүргүүлээд байна.</p> <ul style="list-style-type: none"> • Шар усны үерээс урьдчилан сэргийлэх үзлэг шалгалт хийх Ажлын хэсгийг Хотын Ерөнхий менежерийн 2017 оны 02 дугаар сарын 16-ны өдрийн А/29 дүгээр тушаалаар байгуулж, Улаанбаатар хотын хэмжээнд ажлын хэсгийн гишүүдийг 3 баг болгон хувааж газар дээрхи үзлэгийг 02 дугаар сарын 21, 22-ны өдрүүдэд хийсэн. • 2017-2018 онд төвлөрсөн дулаан хангамжид холбогдох боломжтой 4 сургууль, 1 цэцэрлэг, 2 эмнэлгийн байрны гадна шугам сүлжээ, дулаан дамжуулах төв, холигч насосны узель хийхэд шаардагдах 515,860,000 төгрөгийг НЗД-ын А/615 дугаар захирамжаар хөрөнгийг шийдвэрлүүлсэн. • 2017-2018 оны өвөлжилтийн бэлтгэл хэрхэн хангагдсан талаар хяналт шинжилгээ хийж, дүгнэлт гарган, шаардлагатай арга хэмжээ авах зорилго бүхий Улаанбаатар хотын Ерөнхий менежерийн “Нэрэмжит үзлэг” зохион байгуулах Ажлын хэсгүүдийг Хотын Ерөнхий менежерийн 2017 оны А/115 дугаар тушаалаар байгуулсан. <p>Хэрэгжих шатандаа 70%</p>
		2. 2016-2017 оны өвөлжилтийн явцад инженерийн хангамжийн ашиглалтын байгууллагуудад хяналт тавих	1, 2, 4-р улиралд	<p>Дулааны үр ашгийн төслөөр тавигдсан тоног төхөөрөмжийн ашиглалтын үйл ажиллагааг сайжруулах зорилгоор ОСНААУГ, ТТ, ХҮТ хувийн Орон сууцны конторуудад үүрэг даалгавар өгч ажиллаж байна.</p> <p>2016-2017 оны өвөлжилтийн явцад инженерийн хангамжийн ашиглалтын байгууллагуудад хяналт тавьж ажилласан.</p>

				<p>Өвөлжилтийн тайлан мэдээг Засаг даргын зөвлөлийн хуралд танилцуулсан.</p> <p>Нийслэлийн Засаг даргын 2017 оны 07 дугаар сарын 17-ны “Нийслэлийн 2017-2018 оны өвөлжилтийн бэлтгэл ажлыг хангах зарим арга хэмжээний тухай” 03 тоот албан даалгавар гарсан. Албан даалгаврын дагуу Хотын Ерөнхий менежерийн шуурхай хуралдаанаас харьяа газар, дүүрэг, Засаг даргын хэрэгжүүлэгч зарим агентлагууд үүрэг даалгавар өгч ажиллаж байна.</p> <p>Нийслэлийн нутаг дэвсгэрийн хэмжээнд 2017-2018 оны өвөлжилтийн бэлтгэл хэрхэн хангагдсан талаар хяналт шинжилгээ хийж, дүгнэлт гарган, шаардлагатай арга хэмжээ авах зорилго бүхий Улаанбаатар хотын Ерөнхий менежерийн “Нэрэмжит үзлэг” зохион байгуулах Ажлын хэсгүүдийг Хотын Ерөнхий менежерийн 2017 оны А/115 дугаар тушаалаар байгуулсан. Тус үзлэг шалгалт 2017 оны 10 дугаар сарын 01 хүртэл явагдана. Ажлын хэсгүүд үзлэг, шалгалтыг удирдамжийн дагуу хийж байна.</p> <p>Хэрэгжих шатандаа 90%</p>
		3.Усан хангамж, ариутгах татуургын үйл ажиллагааны хэвийн найдвартай ажиллагааг хангах, шуурхай шийдвэрлэх	Жилдээ	<p>Дүнжингарав хороолол, Бөмбөгөр, Орбитын төмөр замын фрезерийн орчим ф600-ф700 мм-ийн голчтой цэвэр усны шугамд гэмтэл саатал гарсныг холбогдох байгууллагуудтай хамтран гэмтэл саатлыг бүрэн засварлуулж шуурхай шийдвэрлэв.</p> <p>Усан хангамжийн гол шугамуудын гэмтэл саатлын үед мэргэжлийн удирдлагаар шуурхай хангаж, автозам хаах, сэтлэх, бусад мэргэжлийн байгууллагуудтай ажлыг уялдуулан ажиллалаа. Доорхи томоохон гол шугамууд дээр гэмтэл саатал гарсан бөгөөд үүнд: Дүнжингаравын урд Төвийн эх үүсвэрийн гол ф400 мм-ийн шугам, Гандангийн гэр хорооллын захад ф400 мм-ийн гол шугам, Дээд эх үүсвэрийн ф800мм-ийн гол шугам болон бусад гэмтэл саатлыг арилгасан байна.</p> <p>Хотын хөгжлийн төлөвлөлтөд тусгагдсан Баянхошуу, Долоон буудал, Зүүн Сэлбэ бохир усны гол шугамууд баригдаж байгаагаас гадна зураг төсөв нь</p>

					<p>боловсруулагдсан Толгойт, Туул коллекторын 3, 4 дүгээр ээлж, Шинэ Яармаг хороолол, Цайз коллекторын хөрөнгийг шийдвэрлүүлэх саналыг Нийслэлийн Засаг даргын Тамгын газарт хүргүүлээ. Түүнчлэн Америкийн Нэгдсэн Улсын Мянганы Сорилтын сангаас хэрэгжихээр төлөвлөж буй Улаанбаатар хотын усны нөөцийг сайжруулах цогц төсөлд усан хангамж, ариутгах татуургын салбарт хийгдэх ажлыг хийхээр тусгахаар төлөвлөж байна.</p> <p>2017 онд Мянганы сорилтын сангаас усан хангамжийн судалгааны ажил хийхээр төлөвлөсөн байна.</p> <p>Хэрэгжих шатандаа 90%</p>
			<p>4.Айл өрхийн цахилгаан хангамж, нийтийн эзэмшлийн зам талбайн гэрэлтүүлэг, кабель холбооны гэмтэл саатлыг түргэн шуурхай шийдвэрлэх</p>	Жилдээ	<p>2016-2017 оны өвөлжилтийн хугацаанд цахилгаан шугам сүлжээтэй холбоотой аварийн нөхцөл байдал үүссэн 12 асуудалд Хотын Ерөнхий менежерээс авто зам, явган замыг сэтлэх, сүвлэх зөвшөөрөл олгон шийдвэрлэж ажилласан. Нөхөн сэргээлтийн ажлыг дулаарахаар хийлгэхээр авто замын газраас хэмжилт хийж эхэлсэн байна. УБЦТС ТӨХК-ний Зүүн түгээх төвд 3, Баруун түгээх төвд 6 зөвшөөрөл тус тус олгож ажилласан.</p> <p>Улаанбаатар зам засвар арчлалтын газар ОНӨААТҮГ-ын хаврын ажлын хүрээнд хэрэгжүүлэх гэрэлтүүлгийн их засварын ажлын төлөвлөгөөг боловсруулж ерөнхий менежерээр 2017 оны 04 дүгээр сарын 07-ны өдөр батлуулсан. Дээрх төлөвлөгөөнд төвийн 6 дүүргийн нийт 20 байршилд 257,8 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий ажил хийгдэхээр тусгагдсан.</p> <p>Нийтийн эзэмшлийн гэрэлтүүлгийн ашиглалт үйлчилгээг хариуцан ажиллаж байгаа компаниудын санхүүжилтийг шийдвэрлэхдээ УБЗЗАГ хүнд суртал гаргаж байгаа талаар гомдол удаа дараа ирсний дагуу хуучин мөрдөгдөж байсан захирамжаар Захирагчийн ажлын алба гүйцэтгэлд нь хяналт тавьж санхүүжилтийг шийдвэрлэдэг байсныг сэргээх талаар Нийслэлийн Захирагч бөгөөд УБ хотын дарга, зөвлөх, УБ хотын Ерөнхий менежер танилцуулсан.</p> <p>Хэрэгжих шатандаа 90%</p>

			<p>5.Халаалт, дулааныг тасралтгүй хэвийн явуулахад хяналт тавих</p>	<p>Жилдээ</p>	<p>Хэрэглэгчдийг найдвартай төвлөрсөн дулаан хангамжийн системээс хангах мөн агаарын бохирдлыг бууруулах зорилгоор эхний ээлжинд төрийн өмчийн цэцэрлэг, сургуулийг холбохоор ажиллаж байна.</p> <p>Дулааны үр ашгийн төслөөр тавигдсан тоног төхөөрөмжийн ашиглалтын үйл ажиллагааг сайжруулах зорилгоор ОСНААУГ, ТТ, ХҮТ хувийн Орон сууцны конторуудад үүрэг даалгавар өгч ажиллаж байна.</p> <p>Улаанбаатар музейн дулааны шугамын шинэчлэлийн ажлыг гүйцэтгэх компанийг сонгон шалгаруулж шууд гэрээ байгуулах зөвлөмжийг Нийслэлийн Хөрөнгө оруулалтын газарт 2017 оны 08 дугаар сарын 14-ны өдөр хүргүүлсэн болно.</p> <p>Хэрэгжих шатандаа 90%</p>
			<p>6.Орон сууцны цахилгаан, дулаан, усны хэвийн үйл ажиллагааг хангуулах</p>	<p>Жилдээ</p>	<p>Улаанбаатар хотын Ерөнхий менежерийн 2017 оны 01 дүгээр сарын 04-ний өдрийн А/06 дугаар тушаалаар "Орон сууц нийтийн аж ахуйн үйлчилгээ эрхэлж буй хувийн хэвшлийн байгууллагуудын бүтэц зохион байгуулалт, тусгай зөвшөөрөлд тусгагдсан мэргэжлийн боловсон хүчин, дуудлага хүлээн авах, барагдуулахтай холбогдсон үйл ажиллагаатай танилцаж цаашид хэрэгжүүлэх ажлын санал боловсруулах ажлын хэсэг" байгуулагдан хяналт шалгалт хийсэн.</p> <p>Ажлын хүрээнд MNS 5681:2006 "Орон сууцны барилгын үйлчилгээ" стандартын дагуу нийтийн орон сууцны иргэдийг инженерийн дэд бүтцээр найдвартай хангах асуудлаар зөвлөгөө зөвлөмж өгч ажилласан.</p> <p>Улаанбаатар хотын Ерөнхий менежерийн 2017 оны 02 дугаар сарын 20-ны өдрийн А/35 дугаар тушаалаар Улаанбаатар хотын хэмжээний "Барилга байгууламжийн лифт өргөх байгууламжид хяналт шалгалт хийж үнэлэлт дүгнэлт өгөх, цаашид хэрэгжүүлэх ажлын санал боловсруулах ажлын хэсэг" байгуулагдан үзлэг, хяналт шалгалтын ажил хийгдэж байна. Тус ажлын хэсэгт төр, нийслэл болон мэргэжлийн холбоодын мэргэшсэн албан хаагчдын хамтарсан гишүүд хяналт шалгалтын 3 хэсэг болж</p>

				<p>ажиллаж байна. Ажлын хэсэг Нийслэлийн Мэргэжлийн хяналтын газарт бүртгэлтэй орон сууц болон олон нийтийн барилгын 4688 лифтэнд хяналт шалгалт хийнэ. Шалгалтын хугацаанд нийт 1000 гаруй лифтэнд хяналт шалгалт хийсэн байна. Хяналт шалгалтын хүрээнд ноцтой зөрчил илэрсэн аж ахуй нэгж байгууллагын – 1, орон сууцны – 7 нийт 8 лифтийг НМХГ-ын барилгын техникийн хяналтын улсын ахлах байцаагч Г.Эрдэнэхүүд мэдэгдэж зогсоосон. Дээрх үзлэг, шалгалтанд хамрагдсан байгууллага, СӨХ-ны холбогдох албан тушаалтанд лифтний үйл ажиллагааны чиглэлээр илэрсэн зөрчил дутагдлыг арилгах талаар арга зүйн зөвлөгөө болон хууль, дүрэм, стандартын зөвлөгөөг ажлын хэсгийн гишүүд өгч лифт тус бүрт “Зөвлөмж” өгч ажиллаж байна.</p> <p>2017 оны 08 дугаар сарын 15-ны өдрийн А/131 дүгээр тушаалаар барилга байгууламжийн лифт, өргөх байгууламжид хяналт, шалгалт хийж дүгнэлт гаргах ажлын хэсгийг Нийслэлийн Цагдаагийн газраас төлөөлөл оруулан тушаалыг шинэчлэн гаргасан.</p> <p>Энэ тушаалын дагуу 2017 оны 08 дугаар сарын 22-ны өдөр ажлын хэсгийн гишүүд хуралдаж 2017 оны 09 дүгээр сарын 04-ний өдрөөс хяналт шалгалт үргэлжлэн явагдана.</p> <p>2017 оны 07 дугаар сарын 04-ний өдөр БХБЯ-тай хамтран зохион байгуулсан “Орон сууц нийтийн аж ахуйн үйлчилгээний салбарын өмнө тулгамдаж буй асуудлыг төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд шийдвэрлүүлэх нь” сэдэвт хэлэлцүүлгээс гарсан шийдвэрийг тэмдэглэлээр УБ хотын ЕМ танилцуулав.</p> <p>Мөн тус ажлын хүрээнд БХБЯ-нд хамтран ажиллах тухай 2017 оны 01/1688, ЭХЗХ-нд 01/1691 тоот албан бичиг хүргүүлсэн.</p> <p>БХБ-ын сайдын 2017.07.24-ний өдрийн 126 дугаар тушаалаар байгуулагдсан Орон сууцны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судлах, үр нөлөөг үнэлэх, холбогдох зардлын тооцоог гаргах үүрэг бүхий ажлын хэсгийн 2017.08.15-ийн 2 дахь удаагийн хуралд санал өгч оролцон ажилласан.</p>
--	--	--	--	---

					Хэрэгжих шатандаа 90%
			7.Барилгын ашиглалттай холбоотой асуудлыг шийдвэрлэж ажиллах	Жилдээ	<p>Дулаан техникийн шинэчлэл хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд:</p> <p>1.Новосибирск Улаанбаатар хотуудын хооронд найрсаг харилцаа тогтоох тухай 2015 оны 10 дугаар сарын 05-ны өдөр байгуулсан албан ёсны баримт бичгийн хүрээнд Улаанбаатар хотын Ерөнхий менежер бөгөөд Захиаргчийн ажлын албаны дарга Т.Гантөмөр, Ломета ХХК-ийн Ерөнхий захирал А.А.Мороз нар Улаанбаатар хотын угсармал орон сууцны барилгын гадна ханын дулаалгын ажлыг хийх харилцан ойлголцлын санамж бичигт гарын үсэг зурсан. Уг ажлын хүрээнд Ломета ХХК-н Ерөнхий инженер Маклаков А.И, ахлах инженер Черепанов В.В 3, 4-р хорооллын 1 блок 36 айлын угсармал орон сууцны барилгын гадна ханыг дулаалах зорилгоор Баянгол дүүргийн 13-р хорооны 2А байрыг сонгож, зураг төсөл боловсруулах болон дулаалгын ажлыг хийж гүйцэтгэх талаар 03 дугаар сарын 28-30 ны өдрүүдэд манай албан дээр ажилласан.</p> <p>2.Мөн Хан-уул дүүргийн 2-р хороонд 19-р хорооллын 31-р байрыг дулаалах зорилгоор Монгол Базальт ХХК-тай хамтран ажиллаж байна. Одоогийн байдлаар тус компани 31-р байрны дулаалгын ажлын зураг төслийг хийж гүйцэтгэж байна.</p> <p>3.Люксонстракшн ХХК хөнгөн төмөр бетоны технологийг нэвтрүүлэн барилгыг хүчитгэх мөн дулаалах, барилгын залгаас, цонхны амалгаанд чигжээс хийх зэрэг ажлууд дээр хамтран ажиллах, тус компани өөрийн хөрөнгөөр 5 давхар орон сууцны барилгыг дулаалах санал гарган манай албаны зүгээс хамтран ажиллаж байна.</p> <ul style="list-style-type: none"> • Нийслэлийн Засаг даргын А/330 дугаар захирамжаар эрх шилжсэн угсармал орон сууцны барилгыг дулаалах ажлын зураг төсөв боловсруулах ажлаар Улаанбаатар хотын Ерөнхий менежерийн А/84 дүгээр тушаалаар үнэлгээний хороо байгуулагдан “Гандирс-Орд” ХХК шалгарч 2017 оны 08 дугаар сарын 15-ны өдөр НХОГ-д зөвлөмжийг хүргүүлсэн.

					Хэрэгжих шатандаа 90%
			8.Шар усны үерээс урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах, даланг цэвэрлүүлэх	1,2 дугаар улиралд	<p>Шар усны үерээс урьдчилан сэргийлэх үзлэг, шалгалт хийх Ажлын хэсгийг Хотын Ерөнхий менежерийн 2017 оны 02 дугаар сарын 16-ны өдрийн А/29 дүгээр тушаалаар байгуулж, Улаанбаатар хотын хэмжээнд ажлын хэсгийн гишүүдийг 3 баг болгон хувааж газар дээрхи үзлэгийг 02 дугаар сарын 21, 22-ны өдрүүдэд хийсэн. Үзлэгийн дүгнэлтийн дагуу авах арга хэмжээний зөвлөмжийг холбогдох байгууллагуудад хүргүүлсэн. Далан сувгийн цэвэрлэгээ, лаг зайлуулах ажил графикийн дагуу хийгдэж байгаа бөгөөд “Геодези, усны барилга байгууламжийн газар” ОНӨААТҮГ нь Шуурхай удирдлагын төв шинээр байгуулж “Улаанбаатар хотын Шуурхай удирдлага, зохицуулалтын төв” ОНӨААТҮГ болон харьяа байгууллагуудтай нягт холбоотой ажиллаж, харилцан мэдээлэл солилцож байгаа бөгөөд ард иргэд, аж ахуй нэгжүүдийн мэдээллийг 77-200-200 утсаар авч, холбогдох арга хэмжээг тухай бүрт нь авч ажиллаж байна.</p> <p>2017 оны 03 дугаар сард Хотын Ерөнхий менежерийн шуурхай зөвлөгөөнд Геодези, усны барилга байгууламжийн газар ОНӨААТҮГ-ын дарга Цэрэнноров хийж байгаа болон 2017 онд хийгдэх ажлын талаар танилцуулга хийсэн.</p> <p>Нийслэлийн замын сангийн хөрөнгөөр 2017 онд хэрэгжүүлэх ажлын хүрээнд Нийслэлийн Засаг даргын 2017 оны А/144 дүгээр захирамжаар Замын ус зайлуулах шугам, худгийн засвар, өргөтгөлийн ажлын гүйцэтгэгчийг сонгох эрх шилжиж ирсэн. Хотын Ерөнхий менежерийн 2017 оны А/45 дугаар тушаалаар Үнэлгээний хороо байгуулж, Геодези, усны барилга байгууламжийн газар ОНӨААТҮГ-ыг дээрх ажлын гүйцэтгэгчээр сонгон шалгаруулсан тухай зөвлөмж, хурлын тэмдэглэл, захирамж, тушаалыг 2017.04.07-ны 01/481 тоот албан бичгээр нийслэлийн Авто замын хөгжлийн газарт хүргүүлсэн. Тус газраас гэрээ байгуулах мэдэгдлийг Геодези, усны барилга байгууламжийн газар ОНӨААТҮГ-т өгсөн. Нийслэлийн Авто замын хөгжлийн газартай гэрээ байгуулан ажлыг гүйцэтгэж байна.</p>

				<p>Гамшгийн эрсдэлийн менежментийн чадавхийг бэхжүүлэх, байгалийн аюулт үзэгдэл, болзошгүй үер усны гамшгаас урьдчилан сэргийлэх ажлын хүрээнд эрх зүйн орчныг боловсронгуй болгож ашиглалтын үйл ажиллагааг сайжруулахаар одоогийн мөрдөгдөж буй Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2011 оны 102 дугаар тогтоолоор баталсан 6 бүлэг 29 заалт бүхий “Улаанбаатар хотын үерийн хамгаалалтын барилга байгууламж, борооны болон хөрсний ус зайлуулах шугамын хамгаалалтын зурвасын дэглэм, засвар үйлчилгээний журам”-ыг шинэчлэн найруулж 9 бүлэг 68 заалттайгаар “Нийслэлийн инженерийн бэлтгэл арга хэмжээний барилга, байгууламжийн төлөвлөлт, хамгаалалтын зурвас, ашиглалт, засвар үйлчилгээний журам” нэртэйгээр Улаанбаатар хотын Ерөнхий менежерийн зөвлөлийн хурлаар 2017 оны 05 дугаар сарын 09-нд, Нийслэлийн Засаг даргын зөвлөлийн хурлаар 2017 оны 05 дугаар сарын 11-нд тус тус хэлэлцүүлэн, нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Тэргүүлэгчдийн хуралд 2017 оны 05 дугаар сарын 24-нд Нийслэлийн Засаг даргын 01/1976 тоот албан бичгээр тогтоолын төслийг өргөн мэдүүлсэн.</p> <p>Шинээр авто замын борооны ус зайлуулах шугам сүлжээний барилга угсралтын ажлыг 11 байршилд 1,0 тэрбум төгрөгийн Замын сангийн санхүүжилтээр “Геодези, Усны барилга байгууламжийн газар хийж гүйцэтгэхээс 2017 оны 06-р сарын 18-ны байдлаар 3 байршилд 54 ш худаг, 884 у/м хоолой угсарч ажлыг бүрэн дууссан.</p> <p>Хэрэгжих шатандаа 90%</p>
		<p>9.Иргэд, аж ахуй нэгжийг төвлөрсөн дулаан, цахилгаан, мэдээлэл холбооны сүлжээ, усан хангамж, ариутгах татуурга, ус зайлуулах шугам сүлжээнд холбох техникийн нөхцөл олгох</p>	<p>Хагас, бүтэн жил</p>	<p>14 хоног тутамд Нийслэлийн Хот төлөвлөлт, ерөнхий төлөвлөгөөний газрын Мэргэжлийн зөвлөлийн хурлын гишүүнээр хэлтсийн дарга Т.Хэрлэн, Эрчим хүчний яамны төвлөрсөн дулаан хангамжинд холбох техникийн нөхөл олгох комиссын гишүүнээр О.Батмөнх, Эрчим хүчний яамны цахилгаан хангамжинд холбох техникийн нөхөл олгох комиссын гишүүнээр Р.Даваасүрэн, Ус сувгийн удирдах газрын төвийн усан хангамжийн шугамнаас хангах, төвлөрсөн ариутгах татуургын шугамд холбох техникийн нөхцөл олгох комиссын гишүүнээр Л.Алтангэрэл нар</p>

					<p>ажиллаж байна. Ус хангамж, ариутгах татуургын техникийн нөхцөл олгох хүсэлт ирүүлсэн 300 иргэн, аж ахуйн нэгжийн асуудлыг хэлэлцэж, 210 байршлыг техникийн боломжтой гэж үзлээ.</p> <p>Хэрэгжих шатандаа 70%</p>
		10.Авто замын бүрэн бүтэн байдлыг хангуулж ажиллах, цаг үеийн зайлшгүй шаардлагаар авто зам, явган зам сэтлэх тохиолдолд зөвшөөрөл олгох	4 сарын 15-наас 10 сарын 01	<p>Авто зам, замын байгууламжийн бүрэн бүтэн байдлыг хангах, хөдөлгөөний аюулгүй байдлыг хангуулах зорилгоор 2017 оны 04 дүгээр сарын 01-ний их цэвэрлэгээний үеэр Энхтайваны өргөн чөлөөний авто замын хайсыг угаах, цацруулагч наах, ажлуудыг Улаанбаатар зам засвар арчлалтын газар ОНӨААТҮГ-аар гүйцэтгүүллээ.</p> <p>Хан-Уул дүүргийн 120-н явган хүний гүүрэн гарц, 19-н явган хүний гүүрэн гарцыг 2017 оны 04 дүгээр сарын 05-ны өдөр НМХГ-ын Авто замын Улсын ахлах байцаагч Д.Дуламрагчаатай хамтран шалгав. Гүүрэн гарцуудын ашиглалтыг нэмэгдүүлэх, их цэвэрлэгээ хийж хаалга, цонх, шат, бариул, шалыг 04 дүгээр сарын 8, 9, 10-ны өдрүүдэд Бөмбөгөр, 100 айл, 120, 19-н явган хүний гүүрэн гарцуудыг Улаанбаатар зам засвар арчлалтын газар ОНӨААТҮГ-р угааж цэвэрлүүлэв.</p> <p>Улаанбаатар хотын 4 гүүрэн гарц, 1 нүхэн гарцын байгууламжийн ашиглалт, үйлчилгээний ажилд хяналт тавьж ажиллаж байна. Авто замын Улсын ахлах байцаагчтай хамтран гүүрэн гарцын ашиглалтад 04 дүгээр сарын 06-нд хамтарсан үзлэг шалгалтыг хийж ашиглалтын явцад эвдэрсэн лифтийг засварлуулах, хаалга, цонх, бариулыг угаалгасан. Гүүрэн гарцуудын цэвэрлэгээ үйлчилгээ тогтмол хийлгэж хяналт тавин ажиллаж байна.</p> <p>2016-2017 оны өвөлжилтийн хугацаанд цахилгаан, дулаантай холбоотой аваргийн нөхцөл байдал үүссэн 13 асуудалд Хотын Ерөнхий менежерээс авто зам, явган замыг сэтлэх, сүвлэх зөвшөөрөл олгон шийдвэрлэж ажилласан. Нөхөн сэргээлтийн ажлыг дулаарсан үед хийлгэсэн.</p> <p>Нийслэлийн замын сангийн хөрөнгөөр 2017 онд хэрэгжүүлэх ажлын хүрээнд Нийслэлийн Засаг даргын 2017 оны А/144 дүгээр захирамжаар Энхтайваны өргөн чөлөө, Чингисийн</p>	

				<p>өргөн чөлөөний нөхөөс, заадас засварлах, тэмдэглэгээ хийх, гүүрэн гарц, гүүрийн байгууламжийг засварлах, тэмдэг, хайс суурилуулах ажлуудын гүйцэтгэгчийг сонгох эрх шилжиж ирсэн. Хотын Ерөнхий менежерийн 2017 оны А/45 дугаар тушаалаар Үнэлгээний хороо байгуулж, Улаанбаатар зам засвар арчлалтын газар ОНӨААТҮГ-ыг дээрх ажлуудын гүйцэтгэгчээр сонгон шалгаруулсан тухай зөвлөмж, хурлын тэмдэглэл, захирамж, тушаалыг 2017.04.07-ны 01/481 тоот албан бичгээр нийслэлийн Авто замын хөгжлийн газарт хүргүүлсэн. Тус газраас гэрээ байгуулах мэдэгдлийг Улаанбаатар зам засвар арчлалтын газар ОНӨААТҮГ-т өгсөн. Гэрээ байгуулаагүй ч, замын хагарлыг битумээр засварлах заадсын ажил Энхтайваны өргөн чөлөөний зүүн захаас хийгдэж байна. Замын хэвтээ цагаан тэмдэглэгээний ажил шөнийн цагаар хөдөлгөөний эрчим багатай үед хийгдэх ба 4 дүгээр сарын сүүлээр хийгдэх төлөвлөгөөтэй байна. Гэрээ байгуулах шатандаа явж байна.</p> <p>Улаанбаатар хотод инженерийн шугам сүлжээний засвар, үйлчилгээний ажил эхэлсэн тул иргэн, аж ахуйн нэгж, байгууллагуудад авто зам, талбай, тохижилт, ногоон байгууламжийг сэтлэх, сүвлэх, орц, гарц гаргах болон нөхөн сэргээх зөвшөөрлийг зохих журмын дагуу олгож, гүйцэтгэлд нь хяналт тавих үүрэг бүхий Ажлын хэсэг Нийслэлийн Засаг даргын 2017 оны 2017 оны 05 дугаар сарын 11-ний өдрийн А/300 дугаар захирамжаар байгуулагдсан. Ажлын хэсгийн ахлагчаар Улаанбаатар хотын Ерөнхий менежер бөгөөд Захирагчийн ажлын албаны дарга Т.Гантөмөр ажиллаж байгаа бөгөөд ажлын хэсгийн бүрэлдэхүүнд Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны холбогдох хэлтсүүд, Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Бодлого, төлөвлөлтийн хэлтэс, Нийслэлийн Авто замын хөгжлийн газар, Нийслэлийн Тээврийн газар, Замын цагдаагийн алба, Нийслэлийн Хот төлөвлөлт, ерөнхий төлөвлөгөөний газар, Улаанбаатар зам засвар арчлалтын газар ОНӨААТҮГ, Улаанбаатар хотын шуурхай удирдлага зохицуулалтын төв ОНӨҮГ, Замын хөдөлгөөний удирдлагын төв ОНӨҮГ-ууд тус тус ажиллаж байна. Ажлын хэсгийн хурал долоо хоног бүрийн мягмар гаригт хуралдаж иргэн, аж ахуйн нэгж, байгууллагуудаас ирүүлсэн хүсэлтийг шийдвэрлэн ажиллаж байна. Ажлын хэсгийн хуралдаанаар хэлэлцсэний дагуу</p>
--	--	--	--	--

					<p>авто зам сэтлэх, сүвлэх зөвшөөрлийг 60 аж ахуйн нэгж, иргэнд өгөөд байна.</p> <p>Хэрэгжих шатандаа 90%</p>
		11.Нийтийн тээврийн хэрэгслийг цагийн хуваариар ажиллуулахад хяналт тавих, иргэдийн гомдол саналыг барагдуулах		Улирал тутам	<p>Нийтийн тээврийн үйлчилгээний хүртээмжийг орой 21:00-22:00 цагт ажиллах тээврийн хэрэгслийн тоог нэмэгдүүлэх үүднээс зорчигч урсгал багатай өдрийн цагт ажиллах тээврийн хэрэгслийн тоог бууруулж, үйлчилгээний цагийн хуваарийг динамикаар төлөвлөж өдөрт 57 тээврийн хэрэгслийг цонхлуулж, орой 21:00 цагт 99 тээврийн хэрэгслийг нэмэгдүүлж ажилласан байна. Нийтийн тээврийн үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлж ажилласан талаарх мэдээг 14 хоног тутам хотын Ерөнхий менежерийн шуурхай хуралдаанд танилцуулан ажиллаж байгаа бөгөөд иргэдээс ирүүлж буй санал гомдлын тоог 15 хоног тутам авч, харьцуулан үзэхэд 7,27%-иар буурсан үзүүлэлттэй байна. Санал гомдлын тэргүүлэх шалтгаанд жолооч шалгагчийн зан харьцаа 25.4%, Зогсоол дээр зогсоогүй 12.7%, Нийтийн тээврийн үйлчилгээний чиглэл, буудал зогсоол шинээр гаргуулах, сунгах шинэ чиглэл явуулах тухай хүсэлт 47%-ийг эзэлж байна.</p> <p>Нийслэлийн нийтийн тээврийн үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулах ажлын хүрээнд Улаанбаатар хотын Ерөнхий менежерийн 2017 оны А/42 дугаар тушаалаар байгуулагдсан Нийтийн тээврийн үйлчилгээнд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх Ажлын хэсэг батлагдсан удирдамжийн дагуу 2017 оны 03 дугаар сарын 21-ний өдрөөс 2017 оны 03 дугаар сарын 30-ны өдрийг дуустал Нийслэлийн Тээврийн газар болон холбогдох нийтийн тээврийн үйлчилгээ эрхлэгч гэрээт байгууллагуудын үйл ажиллагаатай танилцаж, үйл ажиллагаанд үнэлэлт дүгнэлт өгч ажиллалаа. Ажлын хэсэг нэгдсэн дүгнэлт, зөвлөмжийг нийслэлийн Тээврийн газрын удирдлагуудад өгсөн.</p> <p>Хэрэгжих шатандаа 90%</p>
		12.Хэлтсийн дотор цасны жижүүрийн хуваарь гарган ажиллах	1-3, 10-12-р сар		Хэлтсийн нийт 10 мэргэжилтний 7 хоног бүрээр цасны жижүүрийн хуваарь гарган хэлтсийн даргаар батлуулан, хуваарийн дагуу тухай бүр жижүүрийн ажлыг хийж, цас

				орсон үед НШУЗТ, зам цэвэрлэгээний байгууллагуудад үүрэг чиглэл өгч, шуурхай арга хэмжээ авч ажилласан. Хэрэгжих шатандаа 90%
		13.Дүүрэг болон зам талбайн цэвэрлэгээний байгууллагуудын цас орсон үед шуурхай ажиллах цасны жижүүрийн хуваарийг гаргуулж нэгтгэн НШУЗТ-д хүргүүлэх	2, 10-р сар	Дүүргүүдийн ТҮК болон бусад зам цэвэрлэгээний байгууллага, ХТГ-ын цасны жижүүрийн хуваарийг гаргуулан авч НШУЗТ-д хүргүүлсэн. Хэрэгжих шатандаа 90%
		14.Цас, мөс арилгах тусгай зориулалтын бодис, давсны үлдэгдэл, цасны машин техник, багаж хэрэгслэлийг газар дээр нь шалгаж, шаардлагатай давс, бодис, багаж, хэрэгслэлийг бэлтгүүлэх	2, 9, 10-р сар	2016-2017 оны өвөлжилтийн бэлтгэл ажлыг хангуулахаар дүүргүүдийн ТҮК-уудаар газар дээр нь үзлэг хийж бэлэн байдлыг хангуулж ажилласан бөгөөд өнгөрсөн өвлийн хугацаанд нийслэлийн Засаг даргын нөөц хөрөнгө болон, ЗГ-аас шийдвэрлэсэн хөрөнгөөр нийт 506 тонн давс, 910 тонн цас хайлуулах бодисны худалдан авалтыг хийж, ХТГ болон зам цэвэрлэгээний аж ахуйн нэгжүүдэд хуваарилж, хэрэглэж зарцуулсан. 2017 оны 8 дугаар сарын 25-ны өдөр 902 тн бодис худалдан авхаар гэрээ хийн ажиллаж байна. Хэрэгжих шатандаа 70%
		15.Цас цэвэрлэгээний зориулалттай машин техник, тоног төхөөрөмж худалдан авах ажиллагаанд оролцож, машин техникийн техникийн тодорхойлолтыг гаргаж бэлтгэх, машин техникийг нийлүүлэх гэрээнд хяналт тавих.	2, 4-6-р сар	НЗД-ын 2016 оны 905 дугаар захирамжаар 700 сая төгрөгийн цас цэвэрлэгээний зориулалттай машин техник худалдан авахаар шийдвэр гарсны дагуу НХААГ-ын дарга 2017 оны А/09 дүгээр тушаалаар үнэлгээний хороо байгуулагдаж, тендер зарлагдсан. Дээрх захирамжаар Автозамын цас түрэгч 2, Автозамын цас бутлагч 2, цас цэвэрлэх машин 1, ковш 1, Ачааны автомашин 1, бага оврын олон үйлдэлт трактор 1-ийг тус тус худалдан авах юм. Дээрх техникүүдийн техникийн тодорхойлолтыг ХТГ-аас авч НХААГ-т хүргүүлсэн. Тендерийг 2017 оны 3-р сарын 20-ны өдөр нээхээр товлосон боловч тендер оролцогчоо ШӨХТГ-т гомдол гаргаснаар тендерийн нээлтийг түр хойшлуулан 2017 оны 4-р сарын 11-ний өдөр нээсэн. Дээрх техникүүдийг Хот тохижилтын газар ОНӨААТҮГ-т хүлээлгэн өгөөд байна.

					Хэрэгжих шатандаа 90%
6 заалтын хүрээнд 29 ажлыг төлөвлөн, хэрэгжүүлж 2017 оны 08 дугаар сарын байдлаар:					
Бүрэн биелсэн 100% - 5 ажил					
Хэрэгжих шатандаа 90% -18 ажил					
Хэрэгжих шатандаа 70% -6 ажил нийт 87,5 хувийн хэрэгжилттэй байна.					

ХЯНАСАН:

ЗАХИРГАА, САНХҮҮГИЙН ХЭЛТСИЙН ДАРГА

Э.ЭНХЦЭЦЭГ

НЭГТГЭСЭН:

ШУУРХАЙ АЖИЛ ХАРИУЦСАН АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН

Б.МӨНХБАЯР

БАТЛАВ.

УЛААНБААТАР ХОТЫН ЕРӨНХИЙ МЕНЕЖЕР
БӨГӨӨД ЗАХИРАГЧИЙН АЖЛЫН АЛБАНЫ
ДАРГА Т.ГАНТӨМӨР

2017 оны 02 дугаар сарынөдөр

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН “САХИЛГА ХАРИУЦЛАГА, ДЭГ ЖУРМЫГ САЙЖРУУЛАХ ТУХАЙ”
2017 ОНЫ 02 ДУГААР АЛБАН ДААЛГАВРЫГ ХЭРЭГЖҮҮЛЭХ
АЖЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

2017 оны 01 дүгээр сарын 31

Д/д	Заалтын дугаар	Албан даалгаврын заалт	Хэрэгжүүлэх үйл ажиллагаа	Хугацаа	Хариуцах хэлтэс, нэгж	Хамтарч хэрэгжүүлэх байгууллага
1.	Хоёр.	Төрийн байгууллага, албан тушаалтны сахилга хариуцлагыг өндөржүүлж, гал ус, газар хөдлөлт зэрэг болзошгүй аюулаас урьдчилан сэргийлэх, Төрийн албаны тухай хууль, холбогдох дүрэм журам, заавар, зөвлөмжийн дагуу байгууллагын үйл ажиллагааны төлөвлөлт, гүйцэтгэл, үр дүнг сайжруулах, төрийн албаны стандартыг мөрдөж ажиллах.	1.Албаны хэлтэс, харьяа газруудын захиргааны чиглэлийн дотоод үйл ажиллагаанд батлагдсан төлөвлөгөө, удирдамжийн дагуу дараах чиглэлүүдээр дотоод хяналт, шинжилгээ үнэлгээний ажлуудыг явуулж, хэрэгжилт үр дүнг тооцож тайлагнаж ажиллах. <ul style="list-style-type: none">Нийслэлийн эдийн засаг нийгмийг 2017 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн хэрэгжилт,Албанд хамаарах дээд газрын тогтоол шийдвэр болон бодлогын зорилтын хэрэгжилт,Албаны жилийн үйл ажиллагааны төлөвлөгөө, хэрэгжилт, үр дүн.	Жилдээ	Аудит, дотоод хяналтын хэлтэс	-

			<ul style="list-style-type: none"> • ХЕМ-ийн тушаал, албан даалгаврын хэрэгжилт, • Хотын ерөнхий менежерийн зөвлөлийн хурлын шийдвэрийн хэрэгжилт, • Архив, албан хэрэг хөтлөлт, баримт бичгийн стандартын хэрэгжилт. 			
2.	Гурав.	<p>Төрийн албан хаагчдын хууль тогтоомж, дүрэм журмын хэрэгжилтийг хангуулах, иргэдэд хүнд суртал, чирэгдэл, ёс зүйн доголдол гаргахгүй үйлчлэх, зөрчил гаргасан албан хаагчд</p> <p>ад захиргааны хариуцлага хүлээлгэж холбогдох байгууллага, иргэд, ажилтнууддаа мэдээлдэг байх.</p>	1.Албанд ирсэн өргөдөл гомдлын шийдвэрлэлтэд хяналт шинжилгээ үнэлгээ хийж, үр дүнг Хотын Ерөнхий менежерийн зөвлөлийн хуралд танилцуулж, илтгэх хуудсаар НЗДТГ-т тайлагнаж ажиллах.	2, 4 дүгээр улиралд	Аудит, дотоод хяналтын хэлтсийн Ахлах мэргэжилтэн	-
3.	Тав.	<p>Нийслэлээс зарласан хурал, удирдах ажилтнуудын шуурхай зөвлөгөөн, олон нийтийн арга хэмжээнүүдэд өөрийн биеэр ирж ажил хэрэгч оролцох, хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр хоцорч, таслахгүй байх, нийтээр тэмдэглэх баяр ёслол болон амралтын өдрүүд, ажлын бус цагаар гар утсаа нээлттэй байлгаж, онцгой тохиолдолд ажиллахад бэлэн байх, нийслэлийн удирдлагуудаас цаг үеийн үүссэн нөхцөл байдалтай уялдуулан өгсөн үүрэг даалгаврыг удирдлага, ажилтан нэг бүр шуурхай зохион байгуулж, ажлын явц</p>	1.Нийслэлээс удирдах ажилтны шуурхай зөвлөгөөнөөс өгсөн үүргийн хэрэгжилтэд хяналт тавьж, гүйцэтгэл үр дүнг тооцож, тайлагнаж ажиллах.	Жилдээ	Захиргаа санхүүгийн хэлтэс, Аудит, дотоод хяналтын хэлтэс	-
			2.Удирдлагаас өгсөн чиглэл, байгууллагын дотоод журам болон төрийн албан хаагчийн ёс зүйн дүрэм журмыг мөрдлөг болгож ажиллах, дотоод журмын хэрэгжилтэд хяналт шинжилгээ үнэлгээ хийж ажиллах.	Жилдээ	Аудит, дотоод хяналтын хэлтэс, Захиргаа санхүүгийн хэлтэс	-

		үр дүнг тогтоосон хугацаанд танилцуулж байх.				
4.	6.1.	Хүнсний аюулгүй байдлыг хангах, спирт, согтууруулах ундаа, түргэн муудах, хүнсний бүтээгдэхүүн үйлдвэрлэгч, худалдан борлуулагч, түүгээр үйлчилгээ үзүүлэгч аж ахуйн нэгжийн үйл ажиллагаанд холбогдох хууль тогтоомж, стандартын дагуу тавих байнгын хяналтыг эрс сайжруулж тогтоосон стандарт, байршил, цагийн хуваарийг мөрдлөг болгон сахиулах, илэрсэн зөрчлийг таслан зогсоох, арилгах арга хэмжээг түргэн шуурхай авч ажиллах.	1.Хүнсний биш бараа, жижиглэн худалдааны цэгүүдийн үйл ажиллагаанд холбогдох хууль тогтоомж, шийдвэрийн хэрэгжилтийг хангуулах чиглэлээр мэргэжлийн байгууллагуудтай хамтран хяналт тавьж ажиллах.	1-12 сар	Хүнс, худалдаа, үйлчилгээний хэлтэс	Дүүргүүдийн ЗДТГ-ын Худалдаа, үйлчилгээний хэлтэс, Мэргэжлийн хяналтын хэлтэс, Цагдаагийн хэлтэс
			2.Нийслэлийн төвийн 6 дүүргийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй согтууруулах ундаагаар үйлчлэх тусгай зөвшөөрөлтэй газруудад шалгалт хийх.	1-2 сар	Хүнс, худалдаа, үйлчилгээний хэлтэс	Дүүргүүдийн ЗДТГ-ын Худалдаа, үйлчилгээний хэлтэс Мэргэжлийн хяналтын хэлтэс Цагдаагийн хэлтэс
			3.Согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрлийн хүсэлт ирүүлсэн газруудад анхан шатны хяналт хийж, саналыг Ерөнхий менежерийн Зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж, шийдвэр гаргуулах.	1-12 сар	Хүнс, худалдаа, үйлчилгээний хэлтэс	-
			4.Согтууруулах ундаа худалдах түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрөлтэй газруудыг аттестатчилах.	5-7 сар	Хүнс, худалдаа, үйлчилгээний хэлтэс	Дүүргүүдийн ЗДТГ-ын Худалдаа, үйлчилгээний хэлтэс Мэргэжлийн хяналтын хэлтэс

						Цагдаагийн хэлтэс
			5.Түргэн үйлчилгээний цэгийн худалдаа үйлчилгээ эрхлэгчдийн үйл ажиллагаанд жилд 1-ээс доошгүй удаа хяналт шалгалт явуулж, журмын хэрэгжилтэд хяналт тавьж, гүйцэтгэл үр дүнг тайлагнаж ажиллах.	Жилдээ /1-ээс доошгүй удаа/	Аудит, дотоод хяналтын хэлтэс	-
			6.Согтууруулах ундаа, түүгээр үйлчилгээ үзүүлж буй байгууллагуудад буюу тусгай зөвшөөрөл олгох үйл ажиллагаа, холбогдох журмын хэрэгжилтэд тодорхой арга аргачлалаар хяналт тавьж, гүйцэтгэл үр дүнг тооцож, тайлагнаж ажиллах.	Жилдээ /2-оос доошгүй удаа/	Аудит, дотоод хяналтын хэлтэс	-
			5.Согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрөлтэй газруудад мэргэжлийн байгууллагуудтай хамтран хяналт тавьж ажиллах.	Жилдээ	Хүнс, худалдаа, үйлчилгээний хэлтэс	Дүүргүүдийн ЗДТГ-ын Худалдаа, үйлчилгээний хэлтэс, Мэргэжлийн хяналтын хэлтэс, Цагдаагийн хэлтэс
5	Гурав.	Төрийн албан хаагчдын хууль тогтоомж, дүрэм журмын хэрэгжилтийг хангуулах, иргэдэд хүнд суртал, чирэгдэл, ёс зүйн доголдол гаргахгүй үйлчлэх, зөрчил гаргасан албан хаагчдад захиргааны хариуцлага хүлээлгэж холбогдох байгууллага, иргэд, ажилтнууддаа мэдээлдэг байх.	1.Албаны дотоод журмыг шинэчлэн боловсруулж, батлуулах	1 улирал	Захиргаа, санхүүгийн хэлтэс	
			2.Төрийн албан хаагчдын ёс зүйн дүрмийг шинэчлэн батлуулах	1 улирал	Захиргаа, санхүүгийн хэлтэс	

6	9.1	Инженерийн шугам сүлжээний хэвийн, найдвартай ажиллагааг хангаж, байгууллага, иргэдийг ус, дулаан, цахилгаан хангамжаар тасалдуулахгүй, гэнэтийн гэмтэл, саатал, аливаа эрсдэлээс урьдчилан сэргийлэх, шуурхай ажиллагааны бүлэг, жижүүрийн хуваарь гаргуулах, техник хэрэгслийн бэлэн байдлыг хангуулах үйл ажиллагааг удирдан зохион байгуулах	1.Инженерийн шугам сүлжээний хэвийн, найдвартай ажиллагааг хангах чиглэлээр шуурхай ажиллагааны бүлэг, жижүүрийн хуваарь гаргуулах, техник хэрэгслийн бэлэн байдлыг хангуулах үйл ажиллагааг удирдан зохион байгуулах	Жилдээ	Инженерийн байгууламжийн хэлтэс /	
			2.2016-2017 оны өвөлжилтийн явцад инженерийн хангамжийн ашиглалтын байгууллагуудад хяналт тавих	1, 2, 4-р улиралд	Инженерийн байгууламжийн хэлтэс	
			3.Усан хангамж, ариутгах татуургын үйл ажиллагааны хэвийн найдвартай ажиллагааг хангах, шуурхай шийдвэрлэх	Жилдээ	Инженерийн байгууламжийн хэлтэс	
			4.Айл өрхийн цахилгаан хангамж, нийтийн эзэмшлийн зам талбайн гэрэлтүүлэг, кабель холбооны гэмтэл саатлыг түргэн шуурхай шийдвэрлэх	Жилдээ	Инженерийн байгууламжийн хэлтэс	
			5.Халаалт, дулааныг тасралтгүй хэвийн явуулахад хяналт тавих	Жилдээ	Инженерийн байгууламжийн хэлтэс	
			6.Орон сууцны цахилгаан, дулаан, усны хэвийн үйл ажиллагааг хангуулах	Жилдээ	Инженерийн байгууламжийн хэлтэс Д.Оюунжаргал	
			7.Барилгын ашиглалттай холбоотой асуудлыг шийдвэрлэж ажиллах	Жилдээ	Инженерийн байгууламжийн	

					хэлтэс С.Давааням	
			8.Шар усны үерээс урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах, даланг цэвэрлүүлэх	1-2-р улиралд	Инженерийн байгууламжийн хэлтэс М.Балдандорж	
			9.Иргэд, аж ахуй нэгжийг төвлөрсөн дулаан, цахилгаан, мэдээлэл холбооны сүлжээ, усан хангамж, ариутгах татуурга, ус зайлуулах шугам сүлжээнд холбох техникийн нөхцөл олгох	Хагас, бүтэн жил	Инженерийн байгууламжийн хэлтэс О.Батмөнх Р.Даваасүрэн Л.Алтангэрэл М.Балдандорж	
			10.Авто замын бүрэн бүтэн байдлыг хангуулж ажиллах, цаг үеийн зайлшгүй шаардлагаар авто зам, явган зам сэтлэх тохиолдолд зөвшөөрөл олгох	4 сарын 15-наас 10 сарын 01	Инженерийн байгууламжийн хэлтэс Т.Оюунбилэг	
			11.Нийтийн тээврийн хэрэгслийг цагийн хуваариар ажиллуулахад хяналт тавих, иргэдийн гомдол саналыг барагдуулах	Улирал тутам	Инженерийн байгууламжийн хэлтэс Т.Оюунтөгс	
			12.Хэлтсийн дотор цасны жижүүрийн хуваарь гарган ажиллах	1-3, 10-12-р сар	Тохижилт, хог хаягдлын удирдлагын хэлтсийн мэргэжилтнүүд	
			13.Дүүрэг болон зам талбайн цэвэрлэгээний байгууллагуудын цас орсон үед шуурхай ажиллах цасны жижүүрийн хуваарийг гаргуулж нэгтгэн НШУЗТ-д хүргүүлэх	2, 10-р сар	Тохижилт, хог хаягдлын удирдлагын хэлтэс	

					Т.Энх-Амгалан З.Мөнгөнзул	
			14.Цас, мөс арилгах тусгай зориулалтын бодис, давсны үлдэгдэл, цасны машин техник, багаж хэрэгслэлийг газар дээр нь шалгаж, шаардлагатай давс, бодис, багаж, хэрэгслэлийг бэлтгүүлэх	2, 9, 10-р сар	Тохжилт, хог хаягдлын удирдлагын хэлтэс С.Аригуун Т.Энх-Амгалан З.Мөнгөнзул	
			15.Цас цэвэрлэгээний зориулалттай машин техник, тоног төхөөрөмж худалдан авах ажиллагаанд оролцож, машин техникийн техникийн тодорхойлолтыг гаргаж бэлтгэх, машин техникийг нийлүүлэх гэрээнд хяналт тавих	2, 4-6-р сар	Тохжилт, хог хаягдлын удирдлагын хэлтэс С.Аригуун	
8 заалтын хүрээнд 29 ажлыг төлөвлөж хэрэгжүүлнэ.						

ХЯНАСАН:

ЗАХИРГАА, САНХҮҮГИЙН ХЭЛТСИЙН ДАРГА

Э.ЭНХЦЭЦЭГ

НЭГТГЭСЭН:

ХҮНИЙ НӨӨЦИЙН АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН

Д.МӨНГӨНДУУЛГА

.... оны ... дугаар сарын ..